



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын автобааз" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 265,000,000.00 (хоёр зуун жаран таван сая) төгрөгийн балансын үнэ, 235,897,580.46 (хоёр зуун гучин таван сая найман зуун ерэн долоон мянга таван зуун наян төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг Төрийн тусгай хамгаалалтын газарт 1 дүгээр хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Төрийн тусгай хамгаалалтай газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 297,000,00.00 (хоёр зуун ерэн долоон сая) төгрөгийн балансын үнэ, 87,862,500.00 (наян долоон сая найман зуун жаран хоёр мянга таван зуун) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг "Засгийн газрын автобааз" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт 2 дугаар хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Л.Алтангэрэл, "Засгийн газрын автобааз" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны ... дугаар сарын ... өдрийн
 ... дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
 БҮРТГЭЛТЭЙ, ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ (автомашин)**

| д/д | Автомашин нэр, улсын дугаар | Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он | Нийт гүйлт /км/ | Хэмж их нэгж | Тоо ширхэг | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэх өртөг (төгрөг) |
|-----|---|-----------------------------------|-----------------|--------------|------------|-----------------------------|--|---|
| 1 | Лексус-570 (арлын дугаар-jtjhy00w204230838) | 2016/2016 | 117392 | ш | 1 | 265,000,000.00 | 235,897,580.46 | 29,102,419.54 |
| | Нийт дүн | | | | | 265,000,000.00 | 235,897,580.46 | 29,102,419.54 |
| | | | | | | (хоёр зуун жаран таван сая) | (хоёр зуун гучин таван сая найман зуун ерэн долоон мянга таван зуун наян төгрөг дөчин зургаан мөнгө) | (хорин есөн сая нэг зуун хоёр мянга дөрвөн зуун арван есөн төгрөг тавин дөрвөн мөнгө) |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 03 дугаар сарын 18 өдрийн
 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" ТӨРИЙН
 ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ (автомашин)**

| д/д | Автомашинны нэр, улсын дугаар | Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он | Нийт гүйлт /км/ | Хэмж их нэгж | Тоо ширхэг | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэх өртөг (төгрөг) |
|-----------------|--|-----------------------------------|-----------------|--------------|------------|-----------------------------|--|--|
| 1 | Тоёото ландкрузер-Ж20, (арлын дугаар- JTMHX05J705103645) | 2020/2021 | 90 | ш | 1 | 297,000,000.00 | 87,862,500.00 | 209,137,500.00 |
| | | | | | | 297,000,000.00 | 87,862,500.00 | 209,137,500.00 |
| Нийт дүн | | | | | | (хоёр зуун ерэн долоон сая) | (наян долоон сая найман зуун жаран хоёр мянга таван зуу) | (хоёр зуун есөн сая нэг зуун гучин долоон мянга таван зуу) |